

# **БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТ**

- **Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ**
  - **Байгаль орчны менежментийн төлөвлөгөө**
    - **Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ**

**БОАЖЯ-ны Байгаль орчны үнэлгээ,  
аудитын хэлтсийн ахлах мэргэжилтэн Д.Тэмүүлэн**

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ

Хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхийг хангах зорилгоор байгаль орчин, хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөгүйгээр байгалийн нөөцийг ашиглах, үйлдвэр, үйлчилгээг эрхлэх, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг урьдчилан тогтоох.

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ОЙЛГОЛТ

- Америкийн Нэгдсэн Улс  
*/Байгаль орчны бодлогын тухай. 1960 он./*
- Оросын холбооны улс  
*/Байгаль орчны үнэлгээний журам. 2000 он./*
- Австрали  
*/Өмнөд Австралийн хөгжлийн баримт бичиг. 1993 он./*
- Европын холбооны зарим улсууд  
*/1980-аад оноос/*

## БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ, КОНВЕНЦИ

- Хил дамнасан байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний конвенци. 1991.02.25  
*/ Финлянд улсын Эспү хотноо Албани, Австри, Белорус, Белги, Болгар, Канад, Чех, Дани, Финланд, Франц, Герман, Грек, Итали, Казакстан, Польш, Португали, Швед, Швейцарь, Англи, Америкийн Нэгдсэн Улс зэрэг 45 улс/*
- Байгаль орчны стратегийн үнэлгээний конвенци. 2003.05.21  
*/Украйн улсын Киев хотноо Европын эдийн засгийн комиссын гишүүн орнуудын Байгаль орчны Сайд нарын бага хурал./*

# БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ЭРХ ЗҮЙН ОРЧИН

- Байгаль орчныг хамгаалах тухай хууль  
*/Хоёрдугаар бүлэг. 1995 он./*
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль  
*/1998 онд батлагдсан. 2001 онд нэмэлт өөрчлөлт орсон/*
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай  
хуулийн шинэчилсэн найруулга  
*/2012 оны 05 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан/*
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль  
*/2012 онд нэмэлт өөрчлөлт орсон/*

## ЖУРАМ, ЗААВАР, АРГАЧЛАЛ

- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний журам
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журам
- */Засгийн газрын 2013 оны 374 дүгээр тогтоол/*
- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
- */БОНХ-ийн Сайдын 2014 оны А-05 дугаар тушаал/*
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог хангах тухай журам
- */БОНХ-ийн Сайдын 2014 оны А-04 дугаар тушаал/*
- Байгаль орчны стратегийн болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал
- Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх аргачлал
- */БОНХ-ийн Сайдын 2014 оны А-117 дугаар тушаал/*



## **БАЙГАЛЬ ОРЧИН НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ АНГИЛАЛ**

- **Байгаль орчны стратегийн үнэлгээ**
- **Байгаль орчны төлөв байдлын үнэлгээ**
- **Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ**
- **Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ**

## ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ

Аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг



## БАЙГАЛЬ ОРЧНЫ СТРАТЕГИЙН ҮНЭЛГЭЭ

Улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад түүний хэрэгжилтээс байгаль орчин, нийгэм, хүний эрүүл мэндэд учирч болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөлөл, үр дагаварыг уур амьсгалын чиг хандлага, гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюултай уялдуулан тодорхойлох

## ХУРИМТЛАГДАХ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоох

## БАЙГАЛЬ ОРЧНЫ НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас тодорхой төслийг хэрэгжүүлэх явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагаварыг урьдчилан тодорхойлж, түүнийг бууруулах арилгах арга хэмжээ тогтоох

## ҮНЭЛГЭЭНИЙ МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрхийн ангилал:


- Уул уурхай
- Үйлдвэрлэл, үйлчилгээ
- Дэд бүтэц
- Хөдөө аж ахуй

Одоогоор Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эрх бүхий 171 мэргэжлийн байгууллага байна.

## ОЛОН НИЙТИЙН ОРОЛЦООГ ХАНГАХ

- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд олон нийтийн оролцоог, ялангуяа тухайн төсөл хэрэгжих нутгийн иргэдийн оролцоог хангах зорилгоор олон нийтийн оролцооны талаар тусгай бүлгээр зохицуулсан.
- Орон нутгийн иргэдийн оролцоог идэвхжүүлэх, ялангуяа ашигт малтмал олборлох, боловсруулах төслийг хэрэгжүүлэхэд олон нийтийн оролцоог идэвхжүүлэх, мэдээлэл авах, мэдээллээр хангах, санал авах боломжийг тусгаж өгсөн.
- Олон нийтийн оролцоог хангах журмыг Байгаль орчин, ногоон хөгжил аялал жуулчлалын Сайдын тушаалаар баталсан.

**ТӨСЛИЙН НӨЛӨӨЛӨЛД ШУУД БА ШУУД БУС ХЭЛБЭРЭЭР  
ӨРТӨЖ БОЛЗОШГҮЙ ТУХАЙН ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ  
НУТГИЙГ ИРГЭДЭЭС ГАРГАСАН 372 САНАЛ, ХҮСЭЛТИЙГ  
ТОЙМЛОСОН БАЙДАЛ  
/зөвхөн уул уурхайн төсөл/**





**МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ДАРГА  
БОАЖЯ-НЫ ХБОВНУГ-ЫН ДАРГА, ЕРӨНХИЙ ШИНЖЭЭЧ**

**МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ОРЛОГЧ ДАРГА, БОУАХ-ИЙН ДАРГА**

**МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА**

**МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН ГИШУУД**

**Уул уурхай, хүнд  
үйлдвэрийн яам**

**Эрчим хүчний яам**

**Эрүүл мэндийн яам**

**Боловсрол, соёл, шинжлэх  
ухааны яам**

**Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн  
үйлдвэрийн яам**

**Барилга, хот байгуулалтын  
яам**

**Зам тээврийн хөгжлийн яам**

**Цөмийн энергийн комиссын  
ажлын алба**

**МХЕГ**

**Хими, хими-  
технологийн хүрээлэн**

**Иргэний нийгмийн  
байгууллагын төлөөлөл**

**Төрийн захиргааны удирдлагын газар**

**Газар зохион байгуулалт, усны нэгдсэн  
бодлого зохицуулалтын газар**

**Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын  
газар**


**Ойн бодлого зохицуулалтын газар**

## ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАЛ

Төслийн үйл ажиллагаанд өртөгдсөн байгалийн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ


# ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААРХ СТАТИСТИК ТОО, МЭДЭЭ

## Батлагдсан нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлт, оноор



Дүн: 6723

## Батлагдсан нарийвчилсан үнэлгээний тайлан, оноор



Дүн: 5933

## ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

Ерөнхий үнэлгээний дүгнэлт гаргахад шаардлагатай бичиг баримтад эрх бүхий байгууллагаар батлагдсан техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл шаардаж байгаа нь уул, уурхай ашиглах төслүүдээс бусад төслийн ерөнхий үнэлгээний дүгнэлтийг гаргахад хүндрэл учруулж байна.

## ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланг үнэлгээний мэргэжлийн зөвлөл болон төслийн нөлөөлөлд өртөх орон нутгийн багийн иргэдийн нийтийн хуралд танилцуулж, санал авч байгаа нь тухайн төслийг хэрэгжих орон нутгийн иргэдээс нь санал авч байгаа боловч зарим тохиолдолд БИНХ хуралдахгүй хугацаа алдсанаас төсөл хэрэгжүүлэгч иргэн, аж ахуйн нэгжид хүндрэл учруулж байна.

## ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

Ихэнх мэргэжлийн байгууллагууд ажил эрхлэхэд шаардлагатай мэдээллийн сан, материаллаг бааз, боловсон хүчний чадавхи муутайгаас үнэлгээний тайлан нь өнөөгийн шаардлагыг хангахгүй байна.



## БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлангийн салшгүй хэсэг байна.


Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг тусгах бөгөөд орчны шинжилгээний хөтөлбөр нь салшгүй хэсэг нь байна.

## ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээ.

Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх газар нь тухайн нөлөөлөлд өртсөн газартай адил байгаль экологийн нөхцөлтэй байна.

# ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ





# **АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА**

<http://eic.mn/eia/>